

Захирлын 2021 оны 07 дугээр  
сарын 22.-ны өдрийн 11 дугаар  
тушаалыг 1 дүгээр хавсралт

1117144746  
УХД0072 9104399

## МУИС-ИЙН СУРАЛЦАГЧДАД СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журам нь сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Журмын зорилго нь МУИС-д суралцагчийн төлөвшил, ажил амьдралын зөв дадал эзэмшихэд дэмжин туслах, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор сэтгэл зүйн урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, оношилгоо, зөвлөгөө, сэтгэл заслын анхан шатны үйлчилгээ үзүүлэх, олон нийтэд чиглэсэн сэтгэл зүйн мэдлэг, мэдээлэл түгээх, бие хүнийг хөгжүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулахад оюутны үйлчилгээ хариуцсан нэгж болон Боловсрол, сэтгэл судлал тэнхимийн багш /Сэтгэл зүйч багш, дадлагажигч/ нар хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.3 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг МУИС-ийн Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж болон Боловсрол, сэтгэл судлалын тэнхим хамтран зохион байгуулна.

1.4 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд суурилсан байх ба түүний сонголтыг хүндэтгэнэ.

1.5 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэхдээ энэхүү журмын хавсралт гэрээгээр нарийвчлан зохицуулна.

1.6 МУИС-ийн суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журмын эрх зүйн үндэс нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, МУИС-ийн дүрэм, МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хууль, тогтоомж байна.

1.7 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг МУИС-ийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд заасан сургалтын хугацаанд авах боломжтой.



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 491

Улаанбаатар хот

**Г “МУИС-ийн суралцагчдад сэтгэл  
зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам”  
батлах тухай**

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэг, МУИС-ийн дүрмийн 4.3.1 дэх хэсэг, МУИС-ийн захиргааны зөвлөлийн хурлын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, Зөвлөгөө өгөх өрөөний дотоод журмыг 2 дугаар хавсралтаар, Сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд баримтлах ёс зүйн дүрмийг 3 дугаар хавсралтаар, МУИС-ийн суралцагчид сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 4 дүгээр хавсралтаар, Сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурван талт гэрээг 5 дугаар хавсралтаар, Сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэл бүртгэх хуудсыг 6 дугаар дугаар хавсралтаар тус тус баталж, батлагдсан өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Журамд заасны дагуу сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх ажлыг Оюутан, төгсөгчийн хэлтэс /М.Эрдэнэчимэг/, Боловсрол, сэтгэл судлалын тэнхимиин эрхлэгч / Дэлгэржав / -т тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/-д даалгасугай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Б.ОЧИРХУЯГ

1.8 Нэр томъёоны тайлбар:

А. Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж:

Оюутан, төгсөгчийн хэлтсийн удирдлага, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Б. Сэтгэл зүйч багш:

Боловсрол, сэтгэл судлалын тэнхимиин сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх багш, зөвлөх болон цагийн багш нар

В. Дадлагажигч:

Сэтгэл судлалын чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн Боловсрол, сэтгэл судлалын тэнхимиин магистрант, докторант

Г. Үйлчлүүлэгч:

МУИС-ийн лицей сургуулийн сурагчид, МУИС-ийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн идэвхтэй төлвийн бүх суралцагч

Д. Хувь хүний нууц:

Хувь хүний нууцын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасныг ойлгоно.

Е. Сэтгэл зүйч:

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.19 дүгээр зүйлд заасныг хэлнэ.

**ХОЁР. СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ,  
БАТАЛГААЖУУЛАХ, ЦУЦЛАХ**

2.1 Хүсэлт гаргагч нь МУИС-ийн лицей сургуулийн сурагчид, МУИС-ийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн идэвхитэй төлвийн бүх суралцагчид /үйлчлүүлэгч/ байх бөгөөд сэтгэл зүйн зөвлөгөө авах хүсэлтээ <https://student.num.edu.mn/> /цаашид оюутны вэб хуудас/-нд хандаж зохих заавар, зөвлөмжийн дагуу хүсэлт гаргана.

2.2 Сэтгэл зүйн зөвлөгөө авах хүсэлтийг оюутны вэб хуудсаар дамжуулан урьдчилан захиалах бөгөөд үйлчлүүлэгч өгөгдсөн зааврын дагуу боломжит цагийг сонгон хүсэлт гаргаж баталгаажуулна.

2.3 Сэтгэл зүйн зөвлөгөө авах үйлчилгээтэй холбоотой бичиг баримтыг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжийн холбогдох мэргэжилтэн шалган баталгаажуулж үйлчлүүлэгчийн цахим хаягаар хариу илгээнэ.

2.4 Зөвлөгөөний цаг баталгаажсан тохиолдолд хуваарийг өөрчлөхгүй тул үйлчлүүлэгч тухайн эрэмбэд орох мэдээллийг үнэн зөв баталгаажуулж, хариуцлагатай хандах шаардлагатай.

2.5 Үйлчлүүлэгч хүсэлт гаргасны дараа зөвлөгөөний өрөөнд тохирсон цагаас 10 минутын өмнө очиж дарааллын дагуу үйлчилгээнд хамрагдана.

2.6 Зөвлөгөө авах хүсэлт гаргах, бүртгэх, баталгаажуулахтай холбоотой мэдээллийг МУИС-ийн албан ёсны цахим хуудас болон оюутны вэб хуудас, оюутны үйлчилгээний нэгжийн мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээнэ.

2.7 Суралцагч зөвлөгөө авах хүсэлтийг цуцлах бол 24 цагийн өмнө оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид албан хүсэлт гаргаж цуцлах ба зөвлөгөө авах цагийг

баримтлаагүй тохиолдолд оюутны вэб хуудсанд дахин цаг захиалж хүлээлгийн жагсаалтад орж үйлчлүүлэх эрх авна.

2.8 Хүлээлгийн жагсаалтад байгаа үйлчлүүлэгч нь яаралтай зөвлөгөө, үйлчилгээ авах хүсэлтэй байгаа тохиолдолд бусад сэтгэл зүйн төв мэргэжлийн үйлчилгээний байгууллагын мэдээллийг санал боломжтой.

**ГУРАВ. ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН НЭГЖ, СЭТГЭЛ  
ЗҮЙЧ БАГШ БОЛОН ДАДЛАГАЖИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

**3.1 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжийн эрх, үүрэг**

3.1.1 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээний бодлого, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах эрхтэй.

3.1.2 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь сэтгэл зүйч багш, дадлагажигчийн цагийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах эрхтэй.

3.1.3 Үйлчлүүлэгчийн үйлчилгээний цагийг бүртгэх, хянах, үйлчлүүлэгч болон зөвлөгөө өгөх багштай холбогдох ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

3.1.4 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж, Боловсрол сэтгэл судлалын тэнхимиийн хариуцан ажиллаж буй эрх бүхий багш, ажилтан, дадлагажигч болон зөвлөгөөний өрөөнд буй үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах үүрэгтэй.

3.1.5 Зөвлөгөөний өрөөнд шаардагдах албан хэрэгцээний бичгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах үүрэгтэй.

3.1.6 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээний гүйцэтгэл, төлөвлөгөөний биелэлт, сэтгэл ханамжийн үр дүнг МУИС-ийн захиргаанд тайлагнах үүрэгтэй.

**3.2 Сэтгэл зүйч багш, дадлагажигчийн эрх, үүрэг**

3.2.1 Сэтгэл зүйч багш нь зөвлөгөөний өрөөнд ажиллах дадлагажигчид хоёр долоо хоногт нэг удаа үйл ажиллагааны чиглэл, арга зүйн зөвлөгөөг бүлгээр өгөх ба улирлын эхэнд зөвлөгөө өгөх цагийг товлож өгөх эрхтэй.

3.2.2 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь өрөөний журам (Хавсралт 1) зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох, ажиллуулахгүй байх, дадлагажигчийг солих эрхтэй.

3.2.3 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь үйлчилгээ үзүүлэх байр, өрөөний аюулгүй байдал, эрүүл ахуй, орчин нөхцөлийг сайжруулахад санал гаргаж ажиллах эрхтэй.

3.2.4 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь үзүүлсэн зөвлөгөө, үйлчилгээний ажлын цагийн гүйцэтгэлээ тооцуулах эрхтэй.

3.2.5 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь зөвлөгөөнд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл үйлчлүүлэгчээс хувийн мэдээллийг хүсэх эрхтэй.

3.2.6 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь үйлчлүүлэгчийн нэр, албан тушаалыг нууцалж, дотоод журам, ёс зүйн дүрмийг (Хавсралт 2) баримтлах үүрэгтэй.

3.2.7 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь зөвлөгөө өгөх боломжтой цагаа улирлын эхэнд оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид мэдэгдэж, зөвлөгөөний цагийг товлуулах үүрэгтэй.

3.2.8 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь сэтгэл зүйн үйлчилгээтэй холбоотой оношлогооны аргачлал, үнэлгээ, үнэлгээний хэрэгсэл, үр дүнгийн талаар үйлчлүүлэгчдэд мэдээлэх үүрэгтэй.

#### ДӨРӨВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үйлчлүүлэгч нь зөвлөгөө өгөх үйл явц, сэтгэл зүйч, сэтгэл зүйн зөвлөгөөний талаар мэдээлэл авах эрхтэй.

4.2 Сэтгэл зүйн зөвлөгөөнд сайн дураараа хамрагдах ба хувийн нууцаа хамгаалуулах эрхтэй.

4.3 Зөвлөгөө авах нууцлалын гэрээ байгуулах бөгөөд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний журамтай сайтар танилцсан байна.

4.4 Сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдахдаа чанартай, мэргэшсэн үйлчилгээ авах, шаардлагатай тохиолдолд өөрийн хүсэлтээр зөвлөгөөг зогсоох эрхтэй.

4.5 Тулгамдаж буй асуудлын хүндрэлийн зэргээс хамаарч нэг хичээлийн жилд хамгийн ихдээ 5 хүртэл удаагийн зөвлөгөөнд хамрагдах боломжтой.

4.6 Үйлчлүүлэгчийн хүсэлтээр бусад мэргэжлийн байгууллагад холбон зуучлах үйлчилгээг үзүүлж болно.

4.7 Сэтгэл зүйч болон дадлагажигчтай харилцан хүндэтгэлтэй хандаж, зөвлөгөө өгөх өрөөний дотоод дүрмийг даган мөрдөх үүрэгтэй.

4.8 Сэтгэл зүйн зөвлөгөөний үед өөрийн асуудлыг нээлттэй ярилцах, харилцан санаа бодлоо солилцох, сэтгэл зүйч болон дадлагажигчийн санал болгож байгаа зөвлөмжийг биелүүлэхийг хичээж, хамтран ажиллах үүрэгтэй.

#### ТАВ. БАГШИЙН ЦАГИЙН ГҮЙЦЭТГЭЛ, СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР


##### 5.1 Гүйцэтгэлийн үнэлгээг тооцохдоо:

5.1.1 Нэг удаагийн зөвлөгөө уулзалт нь үйлчлүүлэгчийн асуудлаас хамаараад 90 минутаас хэтрэхгүй байх;

5.1.2 Багшийн тухайн улирлын сургалтын үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээний ажлын ачаалал зэргийг харгалzan үзэж долоо хоногт 3-аас дээш буюу нэг улиралд 48 цагаас дээш зөвлөгөө үйлчилгээний цаг ногдуулахгүй байх;

5.1.3 Сэтгэл зүйч багш, дадлагажигч, цагийн багшийн зөвлөгөөний ажлын улиралд олгоно.

ЗУРГАА. БУСАД



6.1 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг гаргаж МУИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж болно.

6.2 Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж, Боловсрол сэтгэл судлалын тэнхим, сэтгэл зүйч багш болон холбогдох газар, хэлтэс хамтран МУИС-ийн дурэм, журам бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэнэ

XXXX

Захирлын 2021 оны 04 дугаар  
сарын 20-ны өдрийн 14 дугаар  
тушаалыг 2 дугаар хавсралт

1117144746  
УХД0072 9104399

## ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ӨРӨӨНИЙ ДОТООД ЖУРАМ

### 1. Зөвлөгөөний цаг, үйл явц

1.1 Нэг удаагийн зөвлөгөө уулзалт нь үйлчлүүлэгчийн асуудлаас хамаараад 90 минутаас хэтрэхгүй байх

1	Зөвлөгөө үйлчилгээний цагаар шаардлагатай бичиг баримт, мэдээллийг бэлтгэх	10 минут
2	Үйлчлүүлэгчийн уулзалтын цаг	60 минут
3	Зөвлөгөөний дараах сэтгэл ханамжийн судалгаа, дараагийн цагийн төлөвлөлт	10 минут
4	Тухай цагийн уулзалтын тэмдэглэлийг хөтлөх, мэдээллийг мэдээллийн санд нэгтгэх	10 минут

Зөвлөгөөний уулзалтыг цагтаа эхэлж, цагтаа дуусгана. Товлосон цагаас хоцорч ирсэн үйлчлүүлэгчийн хоцорсон хугацааг зөвлөгөөний үргэлжлэх цагаас хасч тооцон үйлчилгээг үзүүлнэ.

1.2 Сэтгэл зүйч багш болон дадлагажигч нар нь анхны уулзалтаар үйлчлүүлэгчид өөрийн мэргэшсэн байдал болон зөвлөгөөний гэрээг танилцуулж, үйлчлүүлэгч зөвшөөрч гарын үсэг зурснаар үйлчилгээг эхлүүлнэ.

1.2.1 Сэтгэл зүйч багш болон дадлагажигч нар хувь хүний хандлага болон мэргэжлийн чадварын дутмаг байдал нь үйл ажиллагаанд саад болж болзошгүй тохиолдолд үйлчлүүлэгчид мэдэгдэн зогсоо буюу бусад мэргэжлийн байгууллагад холбон зуучилж болно.

1.2.2 Зөвлөгөө өгсөн эсэхийг оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид мэдэгдэнэ.

### 2. Сэтгэл зүйч багш, дадлагажигч, үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээлэл

2.1 Үйлчлүүлэгчийн цаг үеийн сэтгэл зүйн байдал, хэрэглэж буй сэтгэл заслын арга техник, зарцуулсан цаг хугацааг байнга тэмдэглэн хөтлөх ба тухайн мэдээллийг зөвлөгөөний өрөөнөөс гаргахгүй байх, нууцлалыг хадгалан ажиллахад анхаарна.

2.2 Үйлчлүүлэгчийн уулзалтын талаар тэмдэглэл хөтөлж, зөвлөгөөний гэрээний хамт хадгална.

2.3 Үйлчлүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр бусад мэргэжлийн байгууллагад зуучлах тохиолдолд үйлчлүүлэгчийн мэдээлэл өгөх эсэхийг шийднэ.

2.4 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нар нь үйлчлүүлэгчтэй мэргэжлийн түвшинд харилцаж, түүнтэй хувийн харилцаа үүсгэх, өөрийн болон бусад сэтгэл зүйчийн (утасны дугаар, цахим хаяг зэрэг) хувийн мэдээллийг өгөхийг хориглоно.

3. Сэтгэл зүйч багш, дадлагажигчийн өрөөнд ажиллах үеийн зарчим

3.1 Үйлчилгээ үзүүлж буй сэтгэл зүйч багш, дадлагажигч нь албан хувцастай байна. (Үүнд: МУИС-ийн логотой цамц хамаарахгүй)

3.2 Зөвлөгөөний үйл явцад саад болох, хэт анхаарал татахуйц гоёл чимэглэл хэрэглэхгүй байна.

3.3 Зөвлөгөө өгөх өрөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана: Үүнд

3.3.1 Зөвлөгөөний дараа цахилгаан хэрэгслийг салгах;

3.3.2 Цонх болон хаалганы бүрэн бүтэн байдлыг шалгах;

3.3.3 Хариуцсан мэргэжилтэнд түлхүүрийг хүлээлгэн өгөх;

3.3.4 Бусад аюулгүй ажиллагааны журмыг баримтлах;

xxxx

Захирлын 2021 оны 04 дугаар  
сарын 20.-ны өдрийн 16 дугаар  
тушаалтыг 3 дугаар хавсралт

1117144746  
УХД0072 9104399

## СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

1. Оюутны үйлчилгээний нэгж, Боловсрол, сэтгэл судлалын тэнхим нь:

1.1 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж болон Боловсрол, сэтгэл судлалын тэнхим нь хэрэглэж буй арга техникийн хэрэглээ, зорилгыг тодорхойлж сэтгэл зүйч багш, дадлагажигчид дэмжлэг үзүүлэх.

1.2 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж болон Боловсрол, сэтгэл судлалын тэнхим нь үйлчлүүлэгчтэй хийсэн гэрээ бусад холбогдох бичиг баримтыг 4 жил хадгална.

1.3 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж болон Боловсрол, сэтгэл судлалын тэнхим нь үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ хүндэтгэлтэй харьцаж үйлчилгээний ёс зүйг баримтална.

1.4 Сэтгэл зүйн үйлчилгээ нь үр нөлөөтэй болоод гэм хоргуй байдлыг хангана.

2. Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь:

2.1 Сэтгэл зүйч багш, дадлагажигчид үйлчлүүлэгчдийнхээ хэл соёл, уламжлал ёс заншил, итгэл үнэмшил, нэр төрийн халдашгүй байдлыг харгалзан гаргасан шийдвэрийг хүндэтгэн хүлээн зөвшөөрнө.

2.2 Сэтгэл зүйч багш, дадлагажигчид үйлчлүүлэгчийн нас, хүйс, биеийн болон хувийн онцлог зэргээр үл хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг хууль ёсны болон ёс зүйн эрхийг хүндэтгэж үзэх.

2.3 Сэтгэл зүйч багш, дадлагажигчид үйлчлүүлэгчийн биеэ авч явж буй байдлыг нь буруушаах, тушааж зааварлах, гутаан доромжлох, албадахаас зайлсхийж, учир шалтгааныг нь ойлгож, хүндэтгэлтэй харилцах.

2.4 Сэтгэл зүйч багш, дадлагажигчид бусад мэргэжлийн хүмүүстэй санал нийлэхгүй байгаа тохиолдолд шүүмжилж буруутгах, бусдын нэр төрд халдахгүй байх.

2.5 Сэтгэл зүйч багш, дадлагажигчид зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх явцдаа дараах тохиолдолд мэргэжлийн бусад хүмүүст мэдээлэх үүрэгтэй Үүнд:

2.5.1 Үйлчлүүлэгчид сэтгэцийн эмгэг, хурц өөрчлөлт илэрсэн бол;

2.5.2 Үйлчлүүлэгч өөрийгөө гэмтээх болон бусдад гэм хор учруулахуйц аюултай бол

2.5.3 Үйлчлүүлэгч амь насанд халтай халдварт өвчинтэй, түүнийгээ бусдад халдаах аюултай бол;

2.5.4 Насанд хүрээгүй этгээд бусдын бэлгийн дарамт болон хүчирхийлэлд байгаа нь тодорхой болсон бол;

2.5.5 Хуулинд зааснаар зайлшгүй илчлэх шаардлагатай мэдээллийг олж мэдсэн бол;

2.5.6 Мансууруулах эм, сэтгэцэд нэлөөт бодис хэрэглэсэн бол;

2.6 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад биений болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал, мэргэжлийн ур чадвар, туршлагаа зөв баримжаалдаг байна.

2.7 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь мэргэжлийн ур чадвараа байнга хөгжүүлнэ.

2.8 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь шинжлэх ухаанч мэдлэгт тулгуурлан сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд өөрийн мэдлэг, чадвар, туршлагыг бүрэн зориулж ажиллана.

2.9 Оношилгооны арга сонгосон үндэслэл, түүнийг удирдан явуулах үйл явцын нарийн алдаагүй байдал, түүнийг тайлбар дүгнэлт зэргийн алдаагүй байдлыг сэтгэл зүйч багш, дадлагажигч нь хариуцна.

2.10 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь зөвхөн дан ганц оношилгооны үр дүнгээр бус өөр бусад оношилгооны арга ашиглан, хувь хүний онцлогт тохирсон зөвлөмжийг харгалзан үзэж дүгнэлт гаргана.

2.11 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь үйлчлүүлэгчтэй зөвлөгөө өгөх харилцаанаас гадуур харилцаа тогтоохыг хориглоно. Үүнд:

2.11.1 Гэр бүлийн, бэлгийн харилцаатай байх;

2.11.2 Санхүүгийн, бизнесийн харилцаатай байх;

2.11.3 Үйлчлүүлэгчээс тусламж, дэмжлэг хүсэх;

2.11.4 Өөрийн эрхшээлд оруулах зэргээр хувийн харилцаанд орох;

2.11.5 Үйлчлүүлэгчийн эмзэг байдлыг ашиглах;

2.12 Хэрэв үйлчлүүлэгчийн асуудлыг тухайн сэтгэл зүйч багш, дадлагажигч шийдвэрлэхэд хязгаарлагдмал байдал үүсч, цаашид зөвлөгөө өгөх боломжгүй болбол өөр сэтгэл зүйч багш, дадлагажигчид шилжүүлж, уг харилцаа холбооноос татгалзах арга хэмжээнүүдийг авах боломжтой.

XXXX

Захирлын 2021 оны 04 дугаар  
сарын 22-ны өдрийн 11 дугаар  
тушаалыг 4 дүгээр хавсралт

1117144746  
УХД0072 9104399

МУИС-ИЙН СУРАЛЦАГЧИД СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

20.... оны .... сарын ....-ны өдөр

№.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас МУИС-ийн сэтгэл зүйч багш/дадлагажигч  
..... овогтой..... (цаашид сэтгэл зүйч) гэх, нөгөө  
талаас сэтгэл зүйн зөвлөгөө авагч ..... овогтой  
..... (цаашид үйлчилгээний үзүүлэх журмыг үндэслэн харилцан тохиролцсоны үндсэн  
зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журмыг үндэслэн харилцан тохиролцсоны үндсэн  
дээр байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Гэрээний зорилго нь МУИС-ийн суралцагчид сэтгэл зүйн зөвлөгөө  
үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагатай  
холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сэтгэл зүйч нь мэргэжлийн өндөр ёс зүйг эрхэмлэж, ажил үүргийн  
хүрээнд олж авсан мэдээллийг чандлан хадгалж, хүний нэр төр, хувийн нууцыг  
хүндэтгэх зарчмыг баримтална.

1.3. Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ нь үйлчилгээний сайн дурын үндэс дээр  
явагдана.

**Хоёр. Гэрээний үйлчлэх хугацаа**

2.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаас хойш сургуулиас олгосон  
төлбөргүй үйлчилгээ авах 5 хүртлэх удаагийн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдаж  
дуусах хүртэл хугацаанд хүчинтэй байна.

2.2. Үйлчлүүлэгч нь гэрээ байгуулсан өдрөөс хойш 5 хүртлэх удаагийн  
зөвлөгөөнд хамрагдана.

2.3. Гэрээний хугацаа дууссаны дараа буюу журмын 5.3-т  
зааснаар үргэлжлүүлэн зөвлөгөө авах бол журамд заасны дагуу төлбөртэй  
үйлчилгээнд хамрагдаж болно.

**Гурав. Зөвлөгч багш, дадлагажигчийн эрх, үүрэг**

3.1. Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь үйлчлүүлэгчийн нэр төр, соёл, итгэл  
үнэмшлийг хүндэтгэх үүрэгтэй.

3.2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх, хамгаалах, хөтлөх үүрэгтэй.

3.3. Ёс зүй болон соёлын хэм хэмжээг баримталж ойлгомжтой цэгцтэй ярих үүрэгтэй.

3.4. Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь үйлчлүүлэгчийн ~~117~~ хувийн нууцыг чандлан хадгалах, үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр ~~УЧП0072.04.04399~~ холбоотой мэдээллийг задруулахгүй байх.

3.5. Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн асуудлаас шалтгаалж оношлох, зөвлөгөө өгөх, дасгал ажиллуулах, сэтгэл зүйн дасгал хийх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үүрэгтэй.

#### Дөрөв. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Үйлчлүүлэгч нь сэтгэл зүйн зөвлөгөөний үед асуудлаа ярилцаж, нээлттэй харилцах үүрэгтэй.

4.2. Үйлчлүүлэгч нь зөвлөгөө авахаа зогсоосон эсвэл зөвлөгөө үр дүнгүй, зөвлөгөө авснаар хохирол амссан нь тодорхой болсон үед харилцаагаа цүцлах үүрэгтэй.

4.3. Үйлчлүүлэгч нь зөвлөгөө үйлчилгээний талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах, бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

4.4. Үйлчлүүлэгч нь зөвлөгөө үйлчилгээний үед ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гаргахгүй байх. Үүнд:

4.4.1. Сэтгэл зүйч, дадлагажигчийн хувийн амьдралыг сонирхохгүй байх;

4.4.2. Дотно сэтгэлийн харилцаа хандлага үүсгэхгүй байх;

#### Тав. Маргааныг шийдвэрлэх

5.1. Үйлчлүүлэгч нь сэтгэл зүйн зөвлөгөө өгөх журмыг зөрчсөн тохиолдолд гэрээг цүцлах хүртэл арга хэмжээ авна.

5.2. Гэрээний биелэлтийн талаар гарсан маргааныг талууд зөвшилцэн шийдвэрлэх ба зөвшилцөөгүй тохиолдолд холбогдох дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

#### Зургаа. Гэрээний талууд

Зөвлөгч багш, дадлагажигч	Үйлчлүүлэгч
Овог нэр: .....	Овог нэр: .....
Утас:	Утас: Яаралтай үед холбоо барих хүний нэр:
Гарын үсэг:	Гарын үсэг:

## Долоо. Мөрдөх зөвлөмж, нууцлалын тухай

7.1. Үйлчлүүлэгч дараах зөвлөмжтэй сайтар танилцан гарын үсэг бүхий зөвшөөрлийг зурснаар зөвлөгөө эхэлнэ. Үүнд:

7.1.1. Сэтгэл зүйн зөвлөгөө өгч буй дадлагажигч нь зөвлөгөө<sup>44</sup> өгөх арга техникт суралцаж байгаа оюутан бөгөөд удирдагч багш нарын удирдлага дор тогтмол ментор зөвлөгөө авч буйг ойлгож зөвлөгөөнд хамрагдах.

7.1.2. Зөвлөгч багш болон дадлагажигч нь аливаа сэтгэцийн эмгэг болон өвчлөлийн оношилгоо хийх эрхгүй гэдгийг ойлгох.

7.1.3. Үйлчлүүлэгч сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдахдаа өөрийн хувийн нууцаа хамгаалулах, чанартай, мэргэшсэн үйлчилгээ авах эрхтэй ба өөрийн хүслээр зөвлөгөөг зогсоож болно.

7.1.4. Үйлчлүүлэгч өөрийн дотоод ертөнцийг нээн гаргаж, сэтгэлийн хөдөлгөөнтэйгээ нүүр тулснаар хүчтэй сэтгэлийн хөдөлгөөнд автах, хүсээгүй бодол зэрэгтэй нүүр тулгарах эрсдэлтэй гэх мэт зөвлөгөө үйлчилгээний үед сэтгэл санаа өөрчлөгдөж болзошгүй тухай мэдээллийг авах.

7.2. Зөвлөгөөний явцад үйлчлүүлэгч нь өөртөө болон бусдад бие махбодын, сэтгэл санааны эрсдэлтэй хор хөнөөл учруулж байгаа, учруулж болзошгүй тохиолдолд зөвлөгч багш, дадлагажигч нь холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

7.3. Гэрээний биелэлтийн талаар гарсан маргааныг талууд зөвшилцэн шийдвэрлэх ба зөвшилцөөгүй тохиолдолд хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

### Гэрээтэй танилцсан:

Үйлчлүүлэгчийн гарын үсэг ..... / .....  
/овог, нэр /гарын үсэг/

Захирлын 2021 оны 04 дугаар  
сарын 26.-ны өдрийн 11 дугаар  
тушаалыг 5 дугаар хавсралт

1117144746  
УХД0072 9104399

СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭХ ГУРВАН ТАЛТ ГЭРЭЭ

20.... оны .... сарын ....-ны өдөр №.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас МУИС-ийг төлөөлж Оюутны үйлчилгээ хариуцсан  
нэгж, түүнийг төлөөлж ..... овогтой .....  
(цаашид "ОҮХН" гэх),

Нэгөө талаас Боловсрол, сэтгэл судлал тэнхим, түүнийг төлөөлж тэнхимийн  
эрхлэгч ..... овогтой ..... (цаашид "БССТ" гэх),

Гуравдагч талаас БССТ-ийн багш болон сэтгэл судлалын чиглэлээр  
бакалаврын боловсрол эзэмшсэн БССТ-ийн магистрант,  
докторант ..... овогтой ..... (цаашид "сэтгэл зүйч  
багш болон дадлагажигч" гэх) (хамтад нь "Талууд" гэх) нар МУИС-ийн  
суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журмыг үндэслэн, дараах  
нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Гэрээний зорилго нь МУИС-ийн суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх  
үйлчилгээ үзүүлэх хугацаанд баримтлах дэг журам, эрх, үүргийг хулээхтэй  
холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Талууд нь сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээг чанартай зохион  
байгуулах, чадварлаг хүний нөөц бүрдүүлж, мэргэжлийн түвшинд сэтгэл зүйн  
зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

**Хоёр. Гэрээний хугацаа**

2.1 Гэрээг гурван хувь хийх бөгөөд гурван тал гарын үсэг зурж  
батлагдсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.

2.2 Сэтгэл зүйн зөвлөгөө дуусгавар болох, эсвэл талуудын хүсэлт  
шаардлагын улмаас харилцан тохиролцож, зөвлөгөөг дуусгавар болгосноор гэрээ  
цуцлагдана.

2.3 Гэрээг хичээлийн жилд нэг удаа байгуулна.

### Гурав. Талуудын эрх, үүрэг

#### 3.1 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжийн эрх, үүрэг

3.1.1 Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээний ~~бодлого, төлөвлөгөө~~ боловсруулан, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах эрхтэй.

3.1.2 БССТ болон сэтгэл зүйч багш, дадлагажигчаас сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээг хэвийн явуулахад шаардлага тавих эрхтэй. Шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд БССТ-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр сэтгэл зүйч багш болон дадлагажигчид хариуцлага тооцох, ажиллуулахгүй байх, солих эрхтэй. Үүнд:

3.1.2.1 Сэтгэл зүйч багш, дадлагажигч нь товлогдсон цагийг 3 ба түүнээс дээш удаа цуцалсан эсвэл 15 минутаас дээш хугацаагаар хоцорсон тохиолдолд;

3.1.2.2 Дадлагажигч нь арга зүйн зөвлөгөөнд хамрагдахгүй байх тохиолдолд;

3.1.2.3 Үйлчлүүлэгчээс сэтгэл зүйч багш болон дадлагажигчийн тухай гомдол, санал ирүүлсэн тохиолдолд;

3.1.2.4 Сэтгэл зүйч багш болон дадлагажигч нь үйлчлүүлэгчтэй ёс зүйн хэм хэмжээг баримтлалгүй харилцан хүндэтгэлгүй харилцсан тохиолдолд;

3.1.2.5 Сэтгэл зүйч багш болон дадлагажигч нь МУИС-ийн суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам, өрөөний дотоод журам, үйлчилгээний гэрээ зэргийг зөрчсөн тохиолдолд.

3.1.3 Сэтгэл зүйч багш, дадлагажигчийн цагийн гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийн үнэлгээг тухайн улиралд багтаан тооцож, цагийн хөлсийг олгуулах үүрэгтэй.

3.1.4 Сэтгэл зүйн зөвлөгөө авах хүсэлтэй суралцагчдад заавар зөвлөмж өгч, мэдээллээр хангах, удирдан чиглүүлэх үүрэгтэй.

3.1.5 Үйлчлүүлэгчийн үйлчилгээний цагийг бүртгэх, хянах үйлчлүүлэгч болон зөвлөгөө өгөх сэтгэл зүйч багш болон дадлагажигчтай холбогдох ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

3.1.6 Сэтгэл зүйч багш болон дадлагажигчийн тухайн улирлын сургалтын үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээний ажлын ачаалал зэргийг харгалzan үзэж долоо хоногт 3-аас буюу улиралд 48 цагаас дээш үйлчилгээний цаг ноогдуулахгүй байх үүрэгтэй.

3.1.7 Үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг хамгаалах, хадгалах, задруулахгүй байх үүрэгтэй.

#### 3.2. Боловсрол, сэтгэл судлал тэнхимиийн эрх, үүрэг

3.2.1. ОҮХН-ийн санал хүсэлтийн дагуу сэтгэл зүйч багш болон дадлагажигч нарт шаардлага тавих эрхтэй.

3.2.2. МУИС-ийн суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам, ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллахыг сэтгэл зүйч багш болон дадлагажигч нараас шаардах эрхтэй.

3.2.3. Сэтгэл зүйч багш болон дадлагажигч нарын гүйцэтгэлийн үнэлгээг ОҮХН-ээс тухайн улиралд баатар тооцож, ажиллахыг шаардах эрхтэй.

3.2.4. Улирлын эхэнд сэтгэл зүйн зөвлөх, үйлчилгээ үзүүлэх сэтгэл зүйч багш болон дадлагажигчийг тухайн улирлын сургалтын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажлын ачаалал зэргийг харгалzan үзэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр томилох үүрэгтэй.

3.2.5. Улирлын эхэнд дадлагажигчид хоёр долоо хоногт нэг удаа арга зүйн зөвлөгөөг бүлгээр үзүүлэх багшийг томилох үүрэгтэй.

### 3.3. Сэтгэл зүйч багш болон дадлагажигчийн эрх үүрэг

3.3.1. Сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн зөвлөгөө, үйлчилгээний ажлын цагийн гүйцэтгэлээ тооцуулах эрхтэй.

3.3.2. Сэтгэл зүйн зөвлөгөөг сэтгэл зүйч багш болон дадлагажигч нар үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр цахимаар болон танхимаар үзүүлэх эрхтэй.

3.3.3. Дадлагажигч нь арга зүйн зөвлөгөөнд тогтмол хамрагдах үүрэгтэй ба зөвлөгөөний үед тулгарч буй бэрхшээл зэргийг хуваалцах, арга зүйн зөвлөгөө авах эрхтэй.

3.3.4. Хэрэв үйлчлүүлэгчийн асуудлыг сэтгэл зүйч багш болон дадлагажигч шийдвэрлэхэд хязгаарлагдмал байдал үүсвэл уг харилцааг зогсоох, эсвэл үйлчлүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд өөр сэтгэл зүйч багш болон дадлагажигчид шилжүүлж эрхтэй.

3.3.5. Сэтгэл зүйч багш болон дадлагажигч нь МУИС-ийн суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам, зөвлөгөөний өрөөний дотоод журам болон ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, ажиллах үүрэгтэй.

3.3.6. Сэтгэл зүйч багш болон дадлагажигч нь зөвлөгөө өгөх боломжтой цагаа улирлын эхэнд оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид мэдэгдэж, зөвлөгөөний цагийг товлуулах үүрэгтэй.

## Дөрөв. Маргааныг шийдвэрлэх

4.1. Талууд нь сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний журам болон өрөөний дотоод дүрмийг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

4.2. Гэрээний биелэлтийн талаар гарсан маргааныг талууд зөвшилцэн шийдвэрлэх ба зөвшилцээгүй тохиолдолд МУИС-ийн холбогдох дүрэм журам, зөвлөгөө үйлчилгээний журмын дагуу шийдвэрлэнэ. Эдгээр журмын дагуу

шийдвэрлэх боломжгүй тохиолдлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Гэрээтэй танилцсан:



Оюутны үйлчилгээ хариуцсан  
нэгжийг төлөөлж гарын үсэг ..... / .....  
/овог, нэр /гарын үсэг/

Боловсрол, сэтгэл судлал тэнхимийг  
төлөөлж, тэнхимийн эрхлэгч ..... / .....  
/овог, нэр /гарын үсэг/

Сэтгэл зүйч багш,  
дадлагажигчийн гарын үсэг ..... / .....  
/овог, нэр /гарын үсэг/

Захирлын 2021 оны 10 дугаар  
сарын 20 -ны өдрийн 10 дугаар  
тушаалыг 6 дугаар хавсралт

1117144746  
УХД0072 9104399

СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАХ ХҮСЭЛТЭЙ  
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ БҮРТГЭХ ХУУДАС

1. Овог: \_\_\_\_\_
2. Нэр: \_\_\_\_\_
3. Огноо: \_\_\_\_\_
4. Суралцагчийн ID дугаар: \_\_\_\_\_
5. Гэрийн хаяг: \_\_\_\_\_
6. Утас: \_\_\_\_\_
7. Яаралтай холбогдох хүний нэр, утас: \_\_\_\_\_
8. Хүйс: \_\_\_\_\_ 9. Нас: \_\_\_\_\_
10. Үндэстэн/ угсаатны бүлэг: \_\_\_\_\_
11. Одоогоор харилцааны ямар статустай байгаа вэ?  
 О Ганц бие, гэрлэж байгаагүй     О Дахин гэрлэсэн     О Бэлэвсэн  
 О Үерхдэг     О Салсан     О Бусад \_\_\_\_\_  
 О Гэрлэсэн     О Гэрлэлтээ цуцалсан
12. Одоогоор хэнтэй амьдардаг вэ?  
 О Ганцаараа     О Гэр бүлтэйгээ  
 О Хамаатан садантайгаа     О Хамтран амьдрагчтайгаа  
 О Өрөөний хамтрагчтайгаа     О Бусад: \_\_\_\_\_
13. Боловсролын түвшин:  
 О Бүрэн бус дунд     О Бүрэн дунд     О Бакалавр  
 О Магистр     О Доктор     О Бусад: \_\_\_\_\_

14. Сургалтын төлөв:

О Өдөр      О Орой      О Эчнээ

О Бусад:

1117144746
Д0072 9104399

15. Ажил эрхлэлтийн байдал:

О Гэртээ хүүхдээ хардаг    О Хагас цагаар  
О Ажилладаггүй    О Ажил хайж байгаа

О Бүтэн цагаар

О Бусад:

16. Өмнө нь сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдаж байсан уу?

О Тийм      О Үгүй

Тийм бол ямар асуудлаар хандаж байсан бэ: \_\_\_\_\_

17. Одоогоор танд ямар нэг эрүүл мэндийн асуудал байгаа юу?

О Тийм      О Үгүй

Тийм бол дэлгэрэнгүй хариулна уу: \_\_\_\_\_

18. Одоогоор ямар нэгэн сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэдэг үү? (жороор  
эсвэл жоргуйгээр)

О Тийм      О Үгүй

Тийм бол эмийн нэрийг бичнэ үү: \_\_\_\_\_

19. Танд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдахад тусгай үйлчилгээ  
шаардлагатай юу?

О Тийм      О Үгүй

Тийм бол дэлгэрэнгүй хариулна уу: \_\_\_\_\_

20. Сэтгэл зүйчтэй ямар асуудлаар ярилцаж, шийдвэрлэх хүсэлтэй байгаагаа  
товч бичнэ үү: \_\_\_\_\_

21. Та өөрт тулгамдаж буй асуудлаа үнэлнэ үү?

хөнгөн	бага зэрэг	дунд зэрэг	хүндэвтэр	маш хүнд
1	2	3	4	5

Үйлчлүүлэгчийн гарын үсэг: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_